



АКПАР АУДИТ ХХК

“ЭРЧИМБАЯН-ӨЛГИЙ” ХК

**2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**АУДИТЫГ ДУУСГАВАР БОЛГОСОН
ТУХАЙ ТАЙЛАН**

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АГУУЛГА:

хуудас

“Акпар-Аудит” компанийн:

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ерөнхий захирал

Х.Баянбай

Аудитын дүгнэлт

2

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

3

Байгууллагын талаархи мэдээлэл

3

Аудитор

М.Хосбаяр

Материаллаг байдлын түвшин

3

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3

Тасралтгүй үйл ажиллагааны талаарх мэдээлэл

3

Балансын дараах үйл явдал

3

Чанарын хяналтын менежер

Д.Хишигсүрэн

Аудит хийгдсэн Санхүүгийн байдлын тайлан

4

Аудит хийгдсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

5

Аудит хийгдсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

5

Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан

6

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал 91919758
дугаарын утсаар харилцана уу

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ХАЯГ:

Баянзүрх дүүрэг, 3-р хороо,

Токиогийн гудамж 45а,

“Ориил төв”-ийн байр, 701 тоот

Мөнгөн хөрөнгө

7

Дансны авлага

7

Татварын авлага

7

Бусад авлага

8

Бараа материал

8

Урьдчилж төлсөн зардал, тооцоо

8

Үндсэн хөрөнгө

9

Үндсэн хөрөнгийн элэгдэл

9

Биет бус хөрөнгө, түүний хорогдол

9

Богино хугацаат өглөг

10

Урт хугацаат өглөг

10

Үйл ажиллагааны орлого

10

Үйл ажиллагааны бус орлого

10

Борлуулсан бүтээгдэхүүний ортог

11

Удирдлагын зардал

11

Аудитороос өгсөн зөвлөмж

11

Утас: 91919758

E-mail: akpar.audit@gmail.com

bayanbai_havdan@yahoo.com

Улаанбаатар хот

2021 оны 3-р сар



“ЭРЧИМБАЯН-ӨЛГИЙ” КОМПАНИЙН УДИРДЛАГАД

Хараат бус аудиторын тайлан

Бид Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг үндэслэн “Эрчимбаян-Өлгий” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан буюу тайлангийн тодруулгуудаас бүрдсэн жилийн эцсийн Санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Эрчимбаян-Өлгий” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. АОУС-д заасан аудиторын хүлээх үүрэг, хариуцлагыг “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага” гэсэн хэсэгт тусгаж харуулав. Аудитын ажилд хамааралтай хараат бус байдлын болон ёс зүйн шаардлагуудыг бүрэн биелүүлж ажилласан. Бидний олж авсан баримт нотолгоонууд дээрх дүгнэлтийг гаргахад хангалттай, тохиромжтой гэж үзэж байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулан, тогтмол мөрдөж ажиллах нь тухайн байгууллагын удирдлагын үүрэг болно.

Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг янз бүрийн зальт ажиллагаанд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь, зарчмыг хангаж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Аудиторын гол зорилго нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд дүгнэлт өгөхөд оршино. Тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловсруулсан горимын дагуу шалгалт хийж, хангалттай, тохиромжтой баримт нотолгоо цуглуулах нь аудиторын үүрэг юм.

Аудитын горимуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу аудитор өөрийн шийдлээр сонгох ба ирүүлсэн алдаа, зөрчил нь материаллаг буюу байгууллагын удирдлага болон хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх эсэхэд дүн шинжилгээ хийж, түүнд тохирсон дүгнэлт өгнө.

Аудитын шалгалтаар байнга алдаа зөрчил илрэх ёстой гэсэн ойлголт байж болохгүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар тодорхой зөвлөгөө өгч ажиллана.

Цаасан болон цахим хэлбэрээр бэлтгэсэн аудитын ажлын баримтууд нь тус компанийн өмч бөгөөд аудиторын тайлан, зөвлөмжийн хамт 10 жил хадгална.



Х.БАЯНБАЙ

Огноо: 2021-03-19

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
3-р хороо, Токиогийн гудамж 45а,
“Оршил төв”-ийн байр, 701 тоот.
Утас: 976-91919758, 976-96969758.
И-мэйл: akpar.audit@gmail.com

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Харилцан тохиролцож байгуулсан гэрээний дагуу “Эрчимбаян-Өлгий” компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг “Аудитын тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Компанийн тухай” хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн боловсруулсан дотоод горимын дагуу гүйцэтгэв.

Байгууллагын талаарх мэдээлэл

1	Байгууллагын нэр	" Эрчимбаян-Өлгий " ХК
2	Компанийн улсын бүртгэлийн дугаар	0210001004
3	Компанийн регистрийн дугаар	2003821
4	Үйл ажиллагааны чиглэл	Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж, цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, ашигт малтмал ашиглах
5	Компанийн хаяг байршил	Баян-Өлгий аймаг, 4-р баг, Их булан 0.

Материаллаг байдлын түвшин

Материаллаг байдлын түвшинг тэвчиж болох хамгийн багаар буюу нийт зардлын 1.0 хувиар тогтооход 45.0 сая төгрөг байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд Акпар-Аудит ХХК аудит хийж гурван зөвлөмж өгсний нэгийг нь биелүүлээгүй байна.

Тасралтгүй үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх, эргэлзээ төрүүлэх нөхцөл байдал илрээгүй.

Балансын дараах үйл явдал

Балансын дараа онцгой зүйл илрээгүй.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2019 он	2020 он
1.ХӨРӨНГӨ		
1.1 Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	21,839,831.10	25,466,748.27
Дансны авлага	1,941,442,807.80	1,313,612,994.61
Татвар, шимтгэлийн авлага	-	182,156.54
Бусад авлага	48,886,147.00	97,097,032.00
Бараа, материал	431,001,758.00	430,508,331.57
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	32,059,272.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	2,443,170,543.90	1,898,926,534.99
1.2 Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,265,013,050.00	3,371,552,679.59
Биет бус хөрөнгө	119,704,800.00	113,719,560.00
Дуусаагүй барилга, байгууламж	456,179,840.00	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,840,897,690.00	3,485,272,239.59
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,284,068,233.90	5,384,198,774.58
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
Дансны өглөг	261,675,167.40	824,076,550.11
Татвар, шимтгэлийн өглөг	110,286,210.50	306,097,786.09
Цалингийн өглөг	-	-
Богино хугацаат зээл	720,000,000.00	46,579,125.47
Урьдчилж орсон орлого	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	18,654,121.60	2,350,900.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,110,615,499.50	1,179,104,361.67
Урт хугацаат зээл	3,291,000,000.00	4,296,576,608.00
Урт хугацаат өр төлбөр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,291,000,000.00	4,296,576,608.00
Өр төлбөрийн нийт дүн	4,401,615,499.50	5,475,680,969.67
2.2 Эзэмшигчдийн өмч		
Хувийн өмч	53,617,700.00	53,617,700.00
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		
Халаасны хувьцаа		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	(171,164,965.60)	(145,099,895.09)
Тайлант үеийн	22,597,134.40	26,065,070.51
Өмнөх үеийн	(193,762,100.00)	(171,164,965.60)
Эзэмшигчдийн өмчийн дүн	(117,547,265.60)	(91,482,195.09)
ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,284,068,233.90	5,384,198,774.58

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
Үндсэн үйл ажиллагааны орлого		
Борлуулалтын орлого	3,961,226,036.90	3,883,639,982.41
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,936,118,109.80	-
Нийт ашиг (алдагдал)	25,107,927.10	3,883,639,982.41
Үйл ажиллагааны зардал		
Үйл ажиллагааны зардал	-	4,499,697,345.38
Үйл ажиллагааны ашиг, (алдагдал)	25,107,927.10	(616,057,362.97)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	-	645,018,552.43
Татвар төлөхийн өмнөх ашиг, (алдагдал)	25,107,927.10	28,961,189.46
Орлогын татварын зардал	2,510,792.70	2,896,118.95
Цэвэр ашиг, (алдагдал)	22,597,134.40	26,065,070.51

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	53,617,700.00	(171,164,965.60)	(117,547,265.60)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
Ногдол ашиг	-	-	-
Тайлант оны ашиг, (алдагдал)	-	26,065,070.51	26,065,070.51
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	53,617,700.00	(145,099,895.09)	(91,482,195.09)

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2019 он	2020 он
<i>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Мөнгөн орлогын дүн	4,613,409,866.80	5,080,488,249.66
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	4,613,409,866.80	3,785,951,929.59
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	3,820,000.00
Бусад	-	1,290,716,320.07
Мөнгөн зарлагын дүн	3,936,118,109.78	5,039,286,154.59
Ажиллагсад олгосон мөнгө	575,834,701.00	781,465,522.21
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	113,935,210.00	121,033,539.94
Түүхий эд, материал худалдан авахад төлсөн мөнгө	622,827,823.78	124,737,641.50
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	511,683,200.00	401,741,115.70
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл	1,546,964,064.00	1,163,557,560.60
Төлсөн хүү	493,777,165.00	664,810,355.09
Татварын байгууллагад төлсөн	8,943,164.00	359,716,368.83
Даатгалын төлбөрт төлсөн	-	3,849,725.00
Бусад	62,152,782.00	1,418,374,325.72
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	677,291,757.02	41,202,095.07
<i>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Мөнгөн орлогын дүн	-	52,012,289.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгааны буцаан төлөлт	-	52,012,289.00
Мөнгөн зарлагын дүн	714,375,425.92	495,328,859.32
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	418,342,710.32
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	21,650,000.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	714,375,425.92	-
Бусад	-	55,336,149.00
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(714,375,425.92)	(443,316,570.32)
<i>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Мөнгөн орлогын дүн	-	1,342,492,688.00
Зээл авсан	-	1,342,492,688.00
Хүүгийн орлого	-	-
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн	-	936,751,295.58
Зээл төлсөн	-	936,236,295.58
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	515,000.00
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Валютын ханшийн зөрүү	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	-	405,741,392.42
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(37,083,668.90)	3,626,917.17
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	58,923,500.00	21,839,831.10
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,839,831.10	25,466,748.27

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОДРУУЛГА

Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө болон түүний эх үүсвэрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө

ХААН, Капитрон, Хас, Төрийн болон Голомт банкинд төгрөгийн, Хас банкинд рублийн харилцах данстай.

Түргэн борлогдох үнэт цаас зэрэг мөнгөн хөрөнгөтэй адилтгах бусад хөрөнгө байхгүй байна.

ҮЗҮҮЛЭЛТ	Валютын төрөл	2019 он	2020 он
<i>Бэлэн мөнгө</i>			
Мөнгөн касс	MNT	-	89,203.27
Бэлэн мөнгөний дүн		-	89,203.27
ХААН банк	MNT	2,248,167.66	4,695,942.00
Голомт банк	MNT	5,667,525.00	9,013,481.00
Капитрон банк	MNT	4,154,780.00	62,264.00
Голомт банк	MNT	6,089,608.66	188.00
Хас банк	MNT	20,292.80	749,985.00
Хас банк	RUB	-	10,583,595.00
Төрийн банк	MNT	3,659,456.99	272,090.00
Банкин дахь мөнгийн дүн		21,839,831.11	25,377,545.00
Нийт мөнгөн хөрөнгийн дүн		21,839,831.11	25,466,748.27

Дансны авлага

Дансны авлага нь орлого гэж хүлээн зөвшөөрөгдсөн боловч хараахан хүлээж аваагүй байгаа бараа, үйлчилгээний үнэ болон бусад өр төлбөрөөс бүрддэг байна.

Авлагыг эцсийн дүнд цуглуулахаар тооцолж буй мөнгөн дүнгээр бүртгэдэг. Санхүүгийн тайланд нийт авлагаас найдваргүй авлагын нөөцийг хассан дүнгээр буюу цэвэр боломжит дүнгээр тусгадаг.

Тус компанийн хувьд харилцагчдаас авах авлагыг дансны авлагаар бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
Төсвийн байгууллагуудаас авах авлага	805,783,071.00	966,764,080.84
Байгууллагуудаас авах авлага	59,488,887.05	157,930,203.40
Орон сууцны айл өрхүүдээс авах авлага	41,920,813.00	188,918,710.37
Орон сууцны айл өрхүүдээс авах авлага	37,348,823.63	-
Орон сууцны айл өрхүүдээс авах авлага	27,531,713.12	-
Берик 4 ХХК	714,375,496.06	-
Өлгий цемент ХХК	254,994,003.94	-
Дансны авлагын нийт дүн	1,941,442,807.80	1,313,612,994.61

Татварын авлага

Тус дансанд илүү төлөгдсөн нийгмийн даатгалын шимтгэл болон бусад татварыг бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
Бусад татварын авлага	-	62,490.00
НДШ-ийн авлага	-	119,666.54
Нийт авлагын дүн	-	182,156.54

Бусад авлага

Бусад авлагаар ажилчин, албан хаагчдаас авах авлагыг бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
ААХ-аас авах авлага	48,886,147.00	44,138,211.00
Бусад авлага	-	50,670,251.00
Дараа тайлангаар	-	2,288,570.00
Нийт дүн	48,886,147.00	97,097,032.00

Бараа материал

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор бэлтгэсэн сэлбэг хэрэгсэл, шатах тослох материал, бараа материал, нүүрс болон хөдөлмөр хамгааллын материалыг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Бараа материалын үлдэгдэл дараах байдалтай байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
Агуулахад байгаа бараа материал	365,381,249.00	256,930,771.57
Нүүрс	55,353,600.00	148,021,440.00
Шатах тослох материал	3,682,492.00	15,433,900.00
Хөдөлмөр хамгааллын материал	2,404,717.00	7,140,270.00
Бичиг хэргийн материал	813,200.00	649,150.00
Ажлын хэрэгцээний зүйлс	-	219,800.00
Бараа материал	-	158,000.00
Ашиглалтад байгаа бараа материал	-	1,955,000.00
Багаж хэрэгсэл	3,366,500.00	-
Бараа материалын дүн	431,001,758.00	430,508,331.57

Урьдчилж төлсөн зардал, тооцоо

Тус дансанд бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа төлбөрийг бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
Маргулан Мендкерей	-	7,284,661.00
Тилек Дамьсхан	-	7,068,717.00
Болатбек Хуантхан	-	5,806,000.00
Нурболат	-	1,800,000.00
Алтанхуяг сэлбэг	-	9,417.00
Тогай Лекей	-	(43,450.00)
Тирлик зах	-	(138,000.00)
Таттимбет Шамен	-	(64,500.00)
Ариунаа-УБ	-	(3,582,300.00)
Бондаренко	-	19,726,727.00
Б.Болатбек	-	30,000.00

“Эрчимбаян-Өлгий” ХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудит

Солар сити инженеринг	-	(5,806,000.00)
Алтыншах ХХК	-	120,000.00
Электрокомплект ХХК	-	(152,000.00)
Нийт дүн	-	32,059,272.00

Үндсэн хөрөнгө

Байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үндсэн хөрөнгийг дараах байдлаар ангилан бүртгэсэн байна.

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	хасагдсан	
Барилга байгууламж	1,599,121,150.00	2,787,531,175.90	-	4,386,652,325.90
Машин тоног төхөөрөмж	1,030,335,000.00	-	154,698,649.40	875,636,350.60
Тээврийн хэрэгсэл	335,000,000.00	-	243,518,658.30	91,481,341.70
Тавилга эд хогшил	114,308,400.00	-	15,951,152.10	98,357,247.90
Компьютер, дагалдах хэрэгсэл	8,100,000.00	-	1,007,500.00	7,092,500.00
Бусад үндсэн хөрөнгө	136,000,000.00	-	136,000,000.00	-
Үндсэн хөрөнгийн дүн	3,222,864,550.00	2,787,531,175.90	551,175,959.80	5,459,219,766.10

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг хөрөнгийн ашиглах хугацааг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулсан байна.

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	хасагдсан	
Барилга байгууламж	1,064,254,200.00	108,366,557.11	-	1,172,620,757.11
Машин тоног төхөөрөмж	797,122,300.00	12,599,985.70	-	809,722,285.70
Тээврийн хэрэгсэл	78,077,400.00	2,935,435.00	-	81,012,835.00
Тавилга эд хогшил	16,537,200.00	4,258,708.70	-	20,795,908.70
Компьютер, дагалдах хэрэгсэл	1,860,400.00	1,654,900.00	-	3,515,300.00
Үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн	1,957,851,500.00	129,815,586.51	-	2,087,667,086.51
Үлдэгдэл өртөг	1,265,013,050.00			3,371,552,679.59

Биет бус хөрөнгө, түүний хорогдол

Тус дансанд тусгай зөвшөөрлийг бүртгэсэн байна.

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	хасагдсан	
Патент	119,704,800.00	-	5,985,240.00	113,719,560.00
Биет бус хөрөнгийн дүн	119,704,800.00	-	5,985,240.00	113,719,560.00

Богино хугацаат өглөг

Богино хугацаат өглөгөөр харилцагч байгууллагад өгөх өглөг, хувь хүмүүст өгөх өглөг, цалингийн өглөг болон дутуу төлөгдсөн татвар, шимтгэлийг бүртгэсэн байна. Богино хугацаат зээлийн дансанд 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Голомт банкнаас авсан жилийн 20.4 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, 2,000.0 сая төгрөгийн зээлийг бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
<i>Дансны өглөг</i>		
Харилцагч байгууллагуудад өгөх өглөг	166,238,504.40	456,271,224.43
Сэлбэгийн өглөг	49,255,250.00	133,003,019.02
Гуанзны өглөг	-	1,200,500.00
Тээврийн хөлсний өглөг	46,181,413.10	213,045,499.66
Нийгмийн хөгжлийн сан /ҮЭ-ийн хураамж	-	1,150,400.00
Хөдөлмөр хамгааллын өглөг	-	9,112,557.00
Аж ахуйн бичиг хэргийн өглөг	-	446,500.00
Ажлын хэрэгцээний зүйлс өглөг	-	195,750.00
Шагах тослох материалын өглөг	-	12,002,000.00
Дансны өглөгийн дүн	261,675,167.50	826,427,450.11
ХХОАТ-ын өр	14,557,319.70	14,785,403.00
ААОАТ-ын өр	6,041,574.60	2,896,118.95
НӨАТ-ын өр	18,441,581.90	266,847,736.28
НДШ-ийн өр	32,132,055.00	-
Суутгагчийн ХХОАТ-ын өр	18,654,121.60	21,568,527.86
Бусад татварын төлбөр	39,113,679.20	-
Татвар, шимтгэлийн өглөгийн дүн	128,940,332.00	306,097,786.09
Цалингийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	-	-
Богино хугацаат зээл-Шугамын зээл	720,000,000.00	46,579,125.47
Богино хугацаат өр, төлбөрийн дүн	1,110,615,499.50	1,179,104,361.67

Урт хугацаат өглөг

Голомт банкнаас авсан зээлийн бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
Банкны урт хугацаат зээл-Шугамын зээл	3,291,000,000.00	4,296,576,608.00
Урт хугацаат зээлийн дүн	3,291,000,000.00	4,296,576,608.00

2020 оны нийт орлого, зардал нь дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны орлого

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
Борлуулалтын орлого	3,961,226,036.90	3,883,639,982.41
Үйл ажиллагааны орлогын дүн	3,961,226,036.90	3,883,639,982.41

Үйл ажиллагааны бус орлого

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
Ханшийн зөрүүний орлого	-	139,013.51
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	1,500,000.00
Бусад орлого	-	643,379,538.92
Үйл ажиллагааны бус орлогын дүн	-	645,018,552.43

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,936,118,109.80	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дүн	3,936,118,109.80	-

Удирдлагын зардал

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он	2020 он
Цалингийн зардал		694,842,713.00
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал		47,345,577.38
Албан татвар, төлбөр хураамжийн зардал		306,621,071.80
Бичиг хэргийн зардал		6,023,070.00
Шуудан холбооны зардал		24,308,410.90
Мэргэжлийн үйлчилгээний зардал		507,100.00
Сургалтын зардал		7,090,000.00
Хэвлэлийн зардал		840,000.00
Даатгалын зардал		3,849,725.00
Засварын зардал		32,656,930.00
Харуул хамгааллын зардал		17,418,100.00
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал		5,662,622.00
Хүлээн авалтын зардал		10,281,235.00
Тээврийн зардал		554,458,962.00
Томилолтын зардал		1,307,100.00
Ашиглалтын зардал		432,865,139.80
Зар сурталчилгааны зардал		2,196,375.00
Элэгдэл, хорогдолын зардал		129,815,596.60
Шатахууны зардал		270,523,610.00
Санхүүгийн зардал		786,877,668.20
Бусад зардал		1,164,206,338.70
Үйл ажиллагааны зардлын дүн	-	4,499,697,345.38

АУДИТОРУУДААС САНАЛ БОЛГОХ ЗӨВЛӨМЖ

Танай компанийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж дууссантай холбогдуулан дараах зөвлөмжийг өгч байна.

1. Санхүүгийн тайлан дахь татварын авлага, өглөгийн үлдэгдэл, татварын цахим систем дэх үлдэгдлээс зөрсөн байна. Татварын байгууллагатай тооцоо нийлж, зөрүүг арилгах.
2. Байгууллагын харилцах дансуудын үлдэгдэл гүйлгээ баланс болон санхүүгийн тайлангийн дүнгээс зөрсөн байна. Цаашид улирал, жилийн эцсийн тайлан гаргах үед данс бүрийн гүйлгээ болон үлдэгдлийг хуулгатай тулган шалгаж байх.

3. Зээлийн дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдэл зээлийн дансны хуулга дахь үлдэгдлээс зөрсөн байна. Улирал, жилийн эцсийн тайлан гаргах үед зээлийн дансны гүйлгээ болон үлдэгдлийг хуулгатай тулган шалгаж байх.
4. Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансанд хасах тэмдэгтэй зардлууд бүртгэлтэй байна. Тооцоо нийлэлтээр ажил гүйцэтгэгч талд өглөгтэй гарвал өглөгийн дансанд, урьдчилж төлсөн зардал бол тухайн дансанд бүртгэдэг байх.
5. Гадаад валютын харилцахын үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийдэггүй байна. Улирал, жилийн эцэст валютын харилцах дансны үлдэгдэлд тухайн улирал, жилийн эцсийн өдрийн Монгол банкнаас тогтоосон ханшийг үндэслэн ханшийн тэгшитгэл хийж байх нь зүйтэй.



“АКПАР-АУДИТ” КОМПАНИ